



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 4/121

Мандалговь

“Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо,
манлайлал” уулзалт арга хэмжээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, 2.1.6 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 5 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн Дундговь аймаг дахь салбараас зохион байгуулж буй “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” уулзалт арга хэмжээнд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх уулзалт арга хэмжээний дэмжлэгт шаардагдах 5,400,000 (Таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100294